



Энэхүү маягыг Hoffman Boston сургуулийн 5-р ангид сурдаг, 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн Jefferson дунд сургуульд дахин харъяалагдах нутаг дэвсгэрт амьдардаг сурагч _____ -н эцэг эх/асран хамгаалагчид зориулан олгож байна.

Хэрэв хэд хэдэн хүүхэд нь 2022-23 оны хичээлийн жилийн дахин төлөвлөлтөд хамрагдсан байвал нэмэлт маягтуудыг ар гэрийнхэнд нь хүргүүлнэ.

АНС нь элсэлт багтаамжаас хэтэрч байгаа болон/эсвэл сүүлийн хоёр хичээлийн жилд элсэлт багтаамжаас хэтэрч байсан эсвэл багтаамж дүүрч байсан, ойрын сургууль нь нэмэлт сурагч авах багтаамжтай сургуулиудад 2021 оны Намрын улиралд харъяалал зохицуулах ажиллагааг хийж байгаа билээ.

АНС нь дараах [төлөвлөлтийн хэсгүүдийг](#) Gunston дунд сургуулиас Jefferson дунд сургуульруу хуваарилахаар төлөвлөж байна: 46140, 48150, 48280, 48281, 48290. Энэхүү өөрчлөлт нь 2022-23 оны хичээлийн жилээс хэрэгжиж эхлэнэ. **Энэхүү харъяаллын дахин төлөвлөлт нь (2021-22 оны хичээлийн жилд 5-р ангид суралцаж буй) 6-р ангид орох бүх сурагчид болон дунд сургуульд шинээр болон ирээдүйд элсэн орох бүх сурагчдад хамаарна.**

Энэхүү маягтын зорилго нь энэхүү харъяаллын дахин төлөвлөлтийн талаарх мэдээллийг таныг авсан болохыг баталгаажуулан энэхүү төлөвлөлтийн хүрээнд таны 5-р ангид сурдаг сурагч 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн Jefferson дунд сургуульд суралцаж эхлэхийг мэдэгдэх явдал юм.

Чөлөөлөгдөх, Ах эгч дүү, Тээврийн мэдээлэл

- **Чөлөөлөгдөх:** Одоо Gunston сургуульд 6, 7-р ангид сурч буй сурагчдад энэхүү дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдөн Gunston сургуульдаа 8-р ангиа төгстөл үргэлжлүүлэн суралцах эсвэл 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн шинээр харъяалагдсан (Jefferson) сургуульд суралцах боломжийг олгох саналыг АНС-н ажилтнууд гаргаж байгаа.
- **Ах эгч дүү:** Дахин төлөвлөлтийн хэсэгт амьдардаг, одоо Gunston сургуулийн 6, 7-р ангид сурдаг сурагчийн дүү нар чөлөөлөгдөх эрхгүй ба дунд сургуульд элсэхдээ (шинээр харъяалагдсан) Jefferson дунд сургуульд орно.
- **Тээвэр:** Одоо 5-р ангид сурч буй сурагчид 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн Jefferson дунд сургуульд элсэн ороход нь АНС-н тээврийн үйлчилгээг олгох ба дахин төлөвлөлтийн хэсэгт амьдардаг 6, 7-р ангийн сурагчдад Gunston сургуульд үргэлжлүүлэн суралцах эсвэл (шинээр харъяалагдсан) Jefferson сургуульд явах сонголт хийснээс үл хамааран үргэлжлүүлэн олгоно. Дахин төлөвлөлтийн хэсэгт амьдардаг, Gunston сургуульд үргэлжлүүлэн суралцах 6, 7-р ангийн сурагчдад сурагавтобусны [хаб зогсоолоор](#) дамжуулан тээврийн үйлчилгээ үзүүлнэ.

Хэрэв танд энэхүү маягыг бөглөхөд туслалцаа хэрэгтэй бол apsboundaries@apsva.us хаягт имэйл бичих эсвэл Hoffman-Boston сургуулийн оффист хандан хоёр хэлтэй ар гэртэй харилцагчтай уулзъя гээрэй.

Энэхүү үйл явцын талаарх нэмэлт мэдээллийг 2021 оны Намрын Харъяаллын дахин төлөвлөлтийн үйл явцын веб хуудас www.apsva.us/engage/fall-2021-boundary-process -аас авна уу.

1. Сурагчийн нэр _____
2. Сурагчийн овог _____
3. Сурагчийн дугаар _____
4. Сурагчийн одоо явж буй сургууль _____
5. Сурагч хэддүгээр ангид сурдаг _____

6. _____ Энэхүү харъяаллын дахин төлөвлөлтийн өөрчлөлтөөр манай 5-р ангид сурдаг хүүхэд 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн Jefferson дунд сургуульд явахыг би хүлээн зөвшөөрч байна.
7. Эцэг эх/асран хамгаалагчийн нэр _____
8. Өдөр холбогддох утас _____
9. Гар утас _____
10. Огноо _____